



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/42/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт хот 2022 он	Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
	Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
	Аудитын менежер: Г.Даваа
	Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
	Аудитор: Б.Ганцэцэг
	Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠐᠒᠒.᠒.᠒᠑ № 58

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онгон сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онгон сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,200,487.43</u>	<u>59,048,737.43</u>
33	АВЛАГА	22,000,000.00	22,000,000.00
335	Бусад авлага	22,000,000.00	22,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	22,000,000.00	22,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,200,487.43	37,048,737.43
354	Хангамжийн материал	12,520,487.43	15,318,737.43
35410	Бичиг хэргийн материал	1,767,800.00	2,425,650.00
35420	Аж ахуйн материал	10,752,687.43	11,898,087.43
35470	Бусад хангамжийн материал	00.00	995,000.00
35600	Мал амьтад	21,680,000.00	21,730,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>821,340,210.18</u>	<u>1,068,089,170.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	821,340,210.18	1,068,089,170.61
392	Биет хөрөнгө	812,556,210.14	1,059,465,170.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	381,061,255.00	481,937,515.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,600,635.47	-85,440,268.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	106,194,800.00	181,293,941.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-104,617,022.48	-110,055,736.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,973,009.00	123,945,768.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,121,888.74	-56,568,524.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,089,346.60	55,089,346.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,718,062.12	-47,402,969.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	662,193,626.00	732,445,360.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-190,898,217.65	-215,779,261.11
393	Биет бус хөрөнгө	8,784,000.04	8,624,000.08
39301	Програм хангамж	2,109,000.00	2,109,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,468,999.96	-1,628,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	8,144,000.00	8,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>877,540,697.61</u>	<u>1,127,137,908.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>890,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	890,000.00
413	Өглөг	00.00	890,000.00
4136	Бусад өглөг	00.00	890,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	890,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>877,540,697.61</u>	<u>1,126,247,908.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	877,540,697.61	1,126,247,908.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	582,814,585.17	582,814,585.17
51101	Өмч: - төрийн	582,814,585.17	582,814,585.17
512	Хуримтлагдсан үр дүн	46,620,094.14	295,327,304.57
51210	Өмнөх үеийн үр дүн	46,620,094.14	46,620,094.14
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	248,707,210.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	248,106,018.30	248,106,018.30

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>877,540,697.61</u>	<u>1,127,137,908.04</u>
----------	--------------------------------------------------------	------------------------------	--------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	561,438,729.00	841,023,173.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,358,228.00	263,120,335.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,358,228.00	263,120,335.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,358,228.00	263,070,335.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,358,228.00	263,070,335.00
120009	Бусад орлого	00.00	50,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	526,080,501.00	577,902,838.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	168,059,101.00	106,560,938.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,652,000.00	18,699,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,687,203.00	75,357,729.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,969,898.00	7,741,109.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	750,000.00	4,762,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358,021,400.00	471,341,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,021,400.00	471,341,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	542,094,627.37	592,315,962.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,094,627.37	592,315,962.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	526,721,521.48	571,109,523.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,065,571.75	247,215,333.74
210101	Үндсэн цалин	197,906,026.79	203,764,569.86
210102	Нэмэгдэл	35,159,544.96	38,968,030.88
210104	Урамшуулал	00.00	335,233.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	4,147,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,603,401.18	35,519,959.24
210201	Тэтгэврийн даатгал	19,889,634.18	24,491,359.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,477,467.00	2,757,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,700.00	2,205,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	482,300.00	551,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,824,300.00	5,514,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,233,459.18	33,201,191.24
210301	Гэрэл, цахилгаан	5,784,482.18	4,939,064.24
210302	Түлш, халаалт	27,428,177.00	28,181,727.00
210303	Цэвэр, бохир ус	20,800.00	80,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,278,946.00	28,703,608.00
210401	Бичиг хэрэг	3,647,150.00	2,769,554.00
210402	Тээвэр, шатахуун	19,441,958.00	21,838,374.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,169,138.00	3,628,180.00

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	92,500.00	138,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	928,200.00	328,900.00
2105	Нормативт зардал	3,811,550.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,152,000.00	00.00
210502	Хоол, хүнс	400,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	259,550.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,262,600.00	5,466,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	600,800.00	957,500.00
210604	Урсгал засвар	661,800.00	4,508,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,590,000.00	4,836,000.00
210702	Дотоод албан томилолт	1,590,000.00	4,836,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,817,914.00	114,346,637.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,074,776.00	112,994,794.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	164,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,500.00	281,881.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	663,500.00	779,492.00
210807	Газрын төлбөр	4,788.00	164,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,058,079.37	101,820,593.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,305,850.00	40,319,410.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	900,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,752,229.37	60,600,933.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,373,105.89	21,206,439.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,982,950.00	6,993,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,183,700.00	6,193,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	799,250.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,390,155.89	14,213,039.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,390,155.89	14,213,039.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>19,344,101.63</u>	<u>248,707,210.43</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>19,344,101.63</u>	<u>248,707,210.43</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь өрөлцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,814,585.17	-16,318,895.14	-1,715,782.65	00.00	564,779,907.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	582,814,585.17	-16,318,895.14	-1,715,782.65	00.00	564,779,907.38
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,242,798.39	00.00	6,242,798.39
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,814,585.17	248,106,018.30	46,620,094.14	00.00	877,540,697.61
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,814,585.17	248,106,018.30	46,620,094.14	00.00	877,540,697.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	582,814,585.17	248,106,018.30	46,620,094.14	00.00	877,540,697.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	248,707,210.43	00.00	248,707,210.43
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,814,585.17	248,106,018.30	295,327,304.57	00.00	1,126,247,908.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>526,080,501.00</u>	<u>577,952,838.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	50,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	50,000.00
120009	Бусад орлого	00.00	50,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	526,080,501.00	577,902,838.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	168,059,101.00	106,560,938.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,652,000.00	18,699,600.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,687,203.00	75,357,729.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,969,898.00	7,741,109.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	750,000.00	4,762,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358,021,400.00	471,341,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,021,400.00	471,341,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>489,201,998.00</u>	<u>531,983,278.70</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,201,998.00	531,983,278.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,828,892.11	510,776,839.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,065,571.75	246,325,333.74
210101	Үндсэн цалин	197,906,026.79	202,874,569.86
210102	Нэмэгдэл	35,159,544.96	38,968,030.88
210104	Урамшуулал	00.00	335,233.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	4,147,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,603,401.18	35,519,959.24
210201	Тэтгэврийн даатгал	19,889,634.18	24,491,359.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,477,467.00	2,757,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,700.00	2,205,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	482,300.00	551,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,824,300.00	5,514,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,233,459.18	33,201,191.24
210301	Гэрэл, цахилгаан	5,784,482.18	4,939,064.24
210302	Түлш, халаалт	27,428,177.00	28,181,727.00
210303	Цэвэр, бохир ус	20,800.00	80,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,564,296.00	29,529,408.00
210401	Бичиг хэрэг	4,208,550.00	3,424,254.00
210402	Тээвэр, шатахуун	19,441,958.00	21,838,374.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,169,138.00	3,628,180.00
210404	Ном, хэвлэл	92,500.00	138,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,652,150.00	500,000.00

2105	Нормативт зардал	3,807,600.00	301,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,152,000.00	00.00
210502	Хоол, хүнс	400,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	255,600.00	301,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,262,600.00	11,738,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	600,800.00	1,512,500.00
210604	Урсгал засвар	661,800.00	10,225,650.00
2107	Томилолт, зочны зардал	1,590,000.00	4,836,000.00
210702	Дотоод албан томилолт	1,590,000.00	4,836,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,222,364.00	107,283,047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,347,226.00	105,900,204.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	164,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,500.00	281,881.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	795,500.00	810,492.00
210807	Газрын төлбөр	4,788.00	164,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,479,600.00	42,042,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,479,600.00	41,142,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	900,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,373,105.89	21,206,439.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,982,950.00	6,993,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,183,700.00	6,193,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	799,250.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,390,155.89	14,213,039.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,390,155.89	14,213,039.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>36,878,503.00</u>	<u>45,969,559.30</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,878,503.00	45,969,559.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,878,503.00	45,969,559.30
2200	Дотоод эх үүсвэрээр	36,878,503.00	45,969,559.30
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,878,503.00	45,969,559.30
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-36,878,503.00</u>	<u>-45,969,559.30</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	481,963,500.00	457,232,360.52

21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,963,500.00	457,232,360.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,970,100.00	450,238,960.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,720,100.00	246,275,333.74
210101	Үндсэн цалин	186,187,200.00	202,824,569.86
210102	Нэмэгдэл	64,147,500.00	38,968,030.88
210104	Урамшуулал	7,345,400.00	335,233.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,147,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,222,300.00	35,519,959.24
210201	Тэтгэврийн даатгал	26,193,700.00	24,491,359.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,757,200.00	2,757,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,205,700.00	2,205,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	551,400.00	551,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,514,300.00	5,514,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,583,700.00	33,201,191.24
210301	Гэрэл, цахилгаан	6,347,700.00	4,939,064.24
210302	Түлш, халаалт	30,136,000.00	28,181,727.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	80,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,457,400.00	27,626,174.00
210401	Бичиг хэрэг	3,057,400.00	3,197,754.00
210402	Тээвэр, шатахуун	20,500,000.00	20,191,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,300,000.00	3,598,180.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	138,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	301,000.00	301,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	301,000.00	301,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,301,000.00	13,284,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,801,000.00	5,801,000.00
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,483,150.00
2107	Томилолт, зочны зардал	6,211,000.00	4,836,000.00
210702	Дотоод албан томилолт	6,211,000.00	4,836,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,252,600.00	6,382,843.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,200.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	304,400.00	281,881.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	898,000.00	810,492.00
210807	Газрын төлбөр	170,000.00	164,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82921000.00	82812309.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,000,000.00	81,912,059.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	921,000.00	900,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6993400.00	6993400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,993,400.00	6,993,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,193,400.00	6,193,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	481,963,500.00	457,232,360.52

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	481,963,500.00	457,232,360.52
132001	Орон нутгийн төсвөөс	481,963,500.00	457,232,360.52
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	106,457,438.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,457,438.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,457,438.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,903,234.00
210401	Бичиг хэрэг	226,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,646,734.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,654,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	911,500.00
210604	Урсгал засвар	2,742,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,900,204.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,900,204.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	106,457,438.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	106,457,438.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,699,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,357,729.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,741,109.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,659,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц

бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 03/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Төрийн албаны нэгдмэл байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албан хаагчдаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү

анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 575.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 263.7 сая төгрөг буюу 30.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	22.0	22.0	0.0
Бараа материал	34.2	37.0	2.8
Үндсэн хөрөнгө	821.3	1068.1	246.8
Нийт хөрөнгө	877.5	1127.1	249.6
Өр төлбөр	0.0	0.9	0.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	877.5	1126.2	248.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	877.5	1127.1	249.6

Авлага дансны үлдэгдэл 22.0 сая төгрөг төлөгдөөгүй байгаа нь 2021 онд цөөн малтай өрхийг дэмжиж, малжуулах төслийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж 11 өрх айлд тус бүр 2.0 сая төгрөгийн мал өгч, 3 жилийн хугацаатай, эргэн төлөгдөх нөхцөлтэй захиргааны гэрээ байгуулсан. Уг гэрээнд 3 жилийн дараа буюу 2023 оны 8 сард тухайн үеийн 2.0 сая төгрөг болон түүнтэй дүйцэхүйц бог мал буцааж өгөх нөхцөлтэй гэрээ байгуулан авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37.0 сая төгрөг болж, 2.8 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал болон цар тахалтай холбоотой эм, эмнэлгийн бэлдмэл бэлтгэсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансанд нийт 16 нэр төрлийн 328.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 06 сарын 08-ны өдрийн 37 дугаар тогтоолоор 20.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 58.4 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,126.2 сая төгрөг болж 248.7 сая төгрөгөөр өссөн байна.

Онгон сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 279.6 сая төгрөг буюу 49.8 хувиар өссөн байна. Нэмэлт санхүүжилтийн орлого 61.5 сая төгрөгөөр хасагдсан бол орон нутгийн төсвөөс санхүүжих 113.3 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 227.7 сая төгрөгөөр өссөн нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 50.2 сая төгрөг буюу 9.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал засварын зардал, дотоод томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд 434.2, багийн урсгал зардалд 57.9 сая төгрөг, нийт 492.1 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 6.3 сая төгрөгөөр бууруулж 427.9 сая, багийн урсгал зардалд 57.9 сая төгрөг баталсан байна. Төсвийн тодотголоор 3.9 сая төгрөгөөр буурч 481,9 сая төгрөгөөр батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 481.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас тайлант хугацаанд 471.3 сая төгрөгийн санхүүжилт авч 457.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 14.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 75.3, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 18.7, туслах үйл ажиллагааны орлогоос 12.6, нийт 106.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс жишиг хашаажуулалтын ажилд 71.5, Шар бүрд булгийн эх хаших ажилд 9.5, ковид 19 цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор эм, эмийн бэлдмэл, тээвэр, шатахууны зардал зэрэгт 25.4, нийт 106.5 сая төгрөгийг зарцуулж, 0.1 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Аймгийн засаг даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулж 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл 94.8 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Онгон сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 140 мэдээллээс хугацаа хоцорсон 54, хугацаандаа оруулсан 86 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгууртай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 22.0 сая төгрөгийн гэрээ байгуулах 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Албан шаардлагыг авч үзвэл:

- Цөөн малтай өрхийг дэмжиж, малжуулах төслийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн боловч эргэн төлөгдөх нөхцөлөөр захиргааны гэрээг байгуулаагүй байсныг албан шаардлагын дагуу хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 95.6 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 95.6 сая төгрөгийн 4 алдаа зөрчлийг залруулж, 3 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

- Шар бүрдний булгийн эх хашсан 6.3 сая төгрөгийн бараа материалыг зарлага болгоогүй;
- Худалдан авсан 2.8 сая төгрөгийн өртөг бүхий нөтбүүхийг картжуулаагүй;
- Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албанаас худалдан авсан 4 багц бүхий хадлангийн тоног төхөөрөмжийн үнийн дүнгийн 30 хувь болох 34.8 сая төгрөгөөр хөрөнгө бүртгэж, тээврийн зардал болох 6.0 сая төгрөгийг шууд зардалд тайлагнасан;
- Ажилчдаас суутгасан 4 сарын хамтын сангийн хураамж 0.8 сая, цалингийн урьдчилгаа илүү суутгасан 0.05 сая, нийт 0.85 сая төгрөгийг өглөгт тусгаж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 6.3 сая төгрөгийн бараа материалыг зардалд тайлагнасан, худалдан авсан нөтбүүхийг картжуулж, хадлангийн тоног төхөөрөмжийн худалдан авах гэрээг үндэслэн нийт үнийн дүн болох 33920 еврог тухайн өдрийн ханшаар тооцон, тээврийн зардлыг тоног төхөөрөмжийн өртөгт шингээн 120.4 сая төгрөгөөр бүртгэж, илүү суутгасан болон цалингийн суутгалыг шилжүүлээгүй нийт 0.85 сая төгрөгийн өглөг үүсгэж залрууллаа.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 124 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Засгийн газрын 43 дугаар тогтоолтой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн зарцуулалтад Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1. “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.2. “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” дахь заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2021 оны 388 тоот тогтоол “Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээ” болон төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа чиглэлийг баримтлан, биелэлтийг ирүүлэх.

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 140 мэдээллээс 54 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нийт 592.1 сая төгрөгийн 26 мэдээллийг ил тод байршуулахаас 437.1 сая төгрөгийн 18 мэдээллийг ил тод байршуулаагүй, мэдээллийг байхгүйгээр мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжид дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дээд шатны байгууллага болон эрх бүхий этгээд дотоод хяналтын журмыг батлаагүй бол Засгийн газрын 2011 оны “НИЙТЛЭГ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын тамгын газар	8	89.6	4	89.6	0	0.0	0	0	4	0